



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/08

Онги

Сумын төвийн урд хойд лагерьт
гэрэлтүүлэг зөөж шилжүүлэх ажлыг хүлээн авах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгөөр сумын төвийн урд хойд лагерьт гэрэлтүүлэг зөөж шилжүүлэх ажлын гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Эрдэнэ (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ц.Саранчимэг (ХАА-н мэргэжилтэн)

Гишүүд: З.Шинэхүү (ЗДТГ-ын нярав)

2. Орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгөөр сумын төвийн урд хойд лагерьт гэрэлтүүлэг зөөж шилжүүлэх ажлын гүйцэтгэлийг хүлээн авахдаа техникийн тодорхойлолтын дагуу хийж гүйцэтгэсэн байдлыг шалган хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.БОЛОРЖАРГАЛ

